



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А-89

Улаанбаатар хот

Урт хугацаат репо арилжааны хэмжээ,
нэмэлт нөхцөлд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт, 13 дугаар зүйл, 15 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалт, 10.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4.1 дэх заалт, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А-425 дугаар тушаалаар батлагдсан Репо арилжааны журмын 2.5 дахь заалт, Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Долоо хоногоос урт хугацаатай репо арилжааны нэмэлт нөхцөлийг энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А-58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалын нэгдүгээр хавсралтад заасан салбарт зээл олгох, олгосон зээлийг дахин санхүүжүүлэх зорилгоор Монголбанкнаас банкуудтай хийх репо арилжааны хэмжээг 2021 оны 2 дугаар улиралд 350 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

4.Урт хугацаат репо арилжааг Төв банкны барьцаа хөрөнгийн жагсаалт дахь активыг барьцаалан хийж, холбогдох журам, гэрээнд заасны дагуу төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гарсны дараа уг үнэт цаасаар барьцааг сольсугай.

5.Энэ тушаалын 3-т заасан репо арилжааны барьцаа хөрөнгийн хугацаа нь репо арилжааны хугацаанаас бага тохиолдолд барьцаа хөрөнгийн шаардлага, хүрэлцээг хангаж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин)-т даалгасугай.

6.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд), Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт, шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус даалгасугай.


7.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 0517



ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ЗЭЭЛИЙН БАГЦ БОЛОН РЕПО
АРИЛЖААГААР АВСАН ЭХ ҮҮСВЭРЭЭР ШИНЭЭР ЗЭЭЛ ОЛГОХ,
ОЛГОСОН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД
ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ	ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ¹ , ХУДАЛДААНЫ САЛБАР
1	Зээлийн ангилал	Зээлийн хугацаанд ангилал буураагүй төгрөгийн зээл байх (Хэвийн зээл)	Зээлийн хугацаанд ангилал буураагүй аж ахуйн нэгжийн төгрөгийн зээл байх (Хэвийн зээл)
2	Зээлийн үлдсэн хугацаа	2 жилээс доошгүй байна	2 жилээс доошгүй байна
3	Зээлийн дээд хэмжээ	3 тэрбум төгрөг	3 тэрбум төгрөг
4	Шинээр олгох зээл, дахин санхүүжүүлэх зээлийн харьцаа	Банк нь Монголбанкнаас авсан санхүүжилтийн 30 хувиас багагүй дүнгээр шинэ зээл олгох	Банк нь Монголбанкнаас авсан санхүүжилтийн 30 хувиас багагүй дүнгээр шинэ зээл олгох
5	Шинээр олгох, дахин санхүүжүүлэх зээлийн хүү	Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна	Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна
6	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	6 сараас доошгүй байна	6 сараас доошгүй байна
7	Зээлийг урьдчилан төлж болох эсэх	Болно	Болно
8	ААН-ийн зээлийн тогтмол төлбөр төлөх боломж	Аж ахуйн нэгжийн хувьд: Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх	Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх

¹ Энд дурдсан Үйлчилгээний салбарт Үндэсний статистикийн хорооноос 2019 онд баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” дахь Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ; Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа; Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа; Урлаг, үзвэр, тоглоом, наадам зэрэг салбарууд хамаарна.

		Иргэдийн хувьд: Сарын ахиуц ашиг (Борлуулалтын орлогоос хувьсах зардлыг хассан дүн) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх	
9	Үйл ажиллагааны тогтвортой байдал	Сүүлийн 6 сар үйл ажиллагаа эрхэлсэн байх	Сүүлийн 6 сар үйл ажиллагаа эрхэлсэн байх
10	Барьцаа хөрөнгийн гөрөл	Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө	Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө
11	Барьцаа хөрөнгийн шалгуур	<p>(i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх;</p> <p>(ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн шилжих боломжтой байх);</p> <p>(iii) Барьцаа хөрөнгө нь үнэт цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжид барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна;</p> <p>(v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх;</p> <p>(vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна.</p>	<p>(i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх;</p> <p>(ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн шилжих боломжтой байх);</p> <p>(iii) Барьцаа хөрөнгө нь үнэт цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжид барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна;</p> <p>(v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх;</p> <p>(vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна.</p>

12	Зээл үнэлгээний харьцаа	Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх	Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх
13	Санхүүгийн тайлангийн шалгуур	Аж ахуйн нэгжийн хувьд: Сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс) Иргэдийн хувьд: Банкны дотоод тайлан болон бусад баримт	Сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс)
14	Бусад	(i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх; (ii) Санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг эргүүлэх төлөх	(i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх; (ii) Санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг эргүүлэх төлөх (iii) Бөөний болон жижиглэн худалдааны салбар нь 200-с доошгүй ажилтантай байна.